

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр

№ ХТ 01/2025

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн 12.00 цагаас 12.30 цагийн хооронд <https://meet.google.com/deq-wnio-bju> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, 115,351,643/нэг зуун арван таван сая гурван зуун тавин нэгэн мянга зургаан зуун дөчин гурав/ хувь буюу 65.70 /жаран тав зууны дал/ хувийг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Т. Золбоо итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.Үүнд:

1. Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах тухай;
3. Төлөөлөн удирдан зөвлөлийн гишүүдийг томилох тухай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг танилцсан учир санал хэлэх хувьцаа эзэмшигч байгаа эсэх талаар санал асуув.

1,2-р хэлэлцэх асуудлаар:

Хурлын дарга Ц. Золбоо: Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья.Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Хуралд оролцож буй санал өгсөн саналыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг санал гарсангүй. Санал дараах байдлтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн				Нийт
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хүчингүй болсон	

2025 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА / Т. ЗОЛБОО/



		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай	115,351,643	100%	-	-	-	-	-	-	115,351,643	100%
2	Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг батлах тухай	115,351,643	100%	-	-	-	-	-	-	115,351,643	100%

Хурлын дарга Т.Золбоо: Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчидээс ТУЗ-ын нэр лэвшигч бүрээр кумулятив аргыг ашиглан хүн тус бүрээр санал хураая.

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр зөвшөөрч эсрэг болон түдгэлзсэн саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2025 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:


- 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлав;
- 2. Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн дүгнэлтийг хэлэлцэж батлав;
- 3. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүнээр Ц.Хүдэрмөнх, Т.Золбоо,Ц.Хуяг,Ц.Хишигбаатар,Б.Батхүү,Г.Аззаяа, Хараат бус гишүүнээр Б.Долгорсүрэн, С.Энхжаргал, Б.Ган-Од нарыг 3 /гурав/-н жилийн хугацаатайгаар томилов.

ХУРЛЫН ДАРГА



/ Т.ЗОЛБОО/

2025 ОНЫ 04-Р САРЫН 30-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



2

/ Т. ЗОЛБОО/